

Докторант С.Мөнхбат
МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш

Намын бүтэц, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтын асуудалд

Өгүүллийн товч утга: Намын бүтэц зохион байгуулалтын асуудал нь нам судлалын үндсэн асуудлуудын нэг юм. Аливаа байгууллага өөрийн бүтэц, зохион байгуулалттай байж өмнөө тавьсан зорилгоо хэрэгжүүлэх боломжтой болдог. Улс төрийн нам судлаач Роберт Михельс "Аливаа зохион байгуулалт нь тодорхой хичээл зүтгэлийн үр дүнд бий болдог ба энэ нь хүчтэйн эсрэг хүчгүйн зэвсэг болдог аугаа их боломжит хүч, нөөц юм"¹ хэмээн тодорхойлсон байдаг. Бүтэц, зохион байгуулалт бий болж байж байгууллага оршин тогтнох үндэс бүрдэнэ. Тиймээс улс төрийн намын хувьд засгийн эрхийг авахын төлөөх зорилгот үйл ажиллагаандаа хүрэх, түүнийг хэрэгжүүлэхийн тулд тогтсон бүтцийг (үйл ажиллагааны, болон үзэл суртлын) бий болгосон байдаг. Энэхүү өгүүлэлд намын бүтэц, зохион байгуулалтын үндсэн зарчим, шинжүүдийг улс төр судлалын тусгай арга болох институциональ хандлагаар судалсан болно.

Түлхүүр үг. Улс төрийн институци, улс төрийн менежмент, институциональ хандлага, корпоратив хэм хэмжээ, төвлөрсөн бүтэц, удирдах аппарат, намын кокус.

Улс төрийн намын үүсэл, төлөвшилтийн үйл явц сонгодог агуулгаараа Өрнө дахинд гарсан хөрөнгөтний хувьсгал, аж үйлдвэржилтийн хөгжилтэй холбосотойгоор тухайн үеийн хаант засаглалыг түлхэн унагаах зорилгоор үүссэн байдаг. Энэхүү институтийн хөгжлийн явц түүний мөн чанар, чиг үүрэг, үүсэл хөгжлийн учир шалтгаан нь парламентат ёсны хөгжилтэй холбоотойгоор улс төрийн системийг бүрэлдүүлэгч элемент болон төлөвшин тогтсоноор илэрдэг. Эхэн үед намууд засгийн эрхийг гартаа авахын төлөө тэмцдэг зохион байгуулалттай бүлэг байхаасаа илүү тодорхой эрх ашгийг хамтгаалах, хадгалах зорилгоос үүдсэн, үзэл санаа нэгт хүмүүсийг нэгтгэсэн дугуйлан, клуб хэлбэртэй оршиж байжээ. Намын хөгжлийн энэ түвшин нь зохион байгуулалтын институтжилтыг өөртөө бий болгож байсан авч нийгмийн зүгээс тэднийг хүлээн зөвшөөрч, хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн нь хожуу XIX зууны сүүл XX зууны эхэн үетэй холбогдоно. Судлаач М.Вебер намын хөгжлийн түүхийг судлаад

1. Эрх ашиг нэгт аристократуудын бүлэглэл
2. Улс төрийн клубууд
3. Олон түмний нам хэмээн ангилсан нь бий

Өнгөрсөн зуунд улс төрийн намууд ихэнхдээ цөөн гишүүнтэй, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа нь хэлбэршин тогтоогүй байв. Намуудын удирдагчид ч өөрсдийн байгууллагуудыг үндсэндээ ээлжит сонгуульд бэлтгэх штаб гэж удтал үзэж байсан нь сонгууль дөхөөд ирэхээр хэрэгжих, хэрэгжихгүй олон юм амлаж гарч ирдэг "эрвээхэй шиг намууд" бий болох боломжийг нээж байсан байна. Харин өнөөгийн нийгмийн хөгжлийн хүрсэн түвшин, хүн зоны улс төрийн ухамсар дээшилсэн байдал, эрх зүйн зохицуулалтын механизмын боловсронгуй байдал зэрэг нь улс төрийн намуудыг байнгын шинжтэй, бат бэх зохион байгуулалтын бүтэцтэй болгож, олон түмнийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг шаардах боллоо. Өөрөөр хэлбэл олон түмний өдөр дутмын амьдрал нөлөөлж байхаар улс төрийн бодлого явуулдаг улс төрийн нам, намын аппарат улам бүр хэрэгтэй болж байна. Өнөөдөр улс төрийн намын үйл ажиллагаа түүний мөн чанарыг улам бүр ойлгох болсон нөхцөлд В.И.Лениний бичсэнчлэн

¹ Robert Michels. Political Parties. A Sociological Study of the Oligarchical Tendencies of Modern Democracy. USA. 1958., P. 25

“тэднийг нэрээр нь бус, үг яриагаар нь бус, харин юуны өмнө түүний ажлаар нь түүний үйл ажиллагааны практик үр дүнгээр нь дүгнэх ёстой”¹ болж байна.

Үндсэн хуульт төр, парламентат ёсны хөгжлийг дагаад намууд өөрсдийн улс төр, эрх зүйн статусаа аажмаар бэхжүүлж чадснаар энэхүү байгууллага нь улс төрийн харилцааны эрх зүйн зохицуулалтын нэгэн өвөрмөц субъект, төрийн бодлогыг боловсруулан гаргахад шууд оролцдог онцгой байгууллага болон байна. Тиймээс ч улс төрийн намыг судлан шинжилж, танин мэдэх нь улс төрийн талаарх ардчилсан үнэлэмжийг төлөвшүүлэхэд нөлөө үзүүлэх агаад энэ нь олон талын судалгаа, шинжилгээг шаардах нь гарцаагүй. Энэхүү олон талт судалгааны нэг нь түүний бүтэц, зохион байгуулалтын асуудал билээ.

Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын асуудал нь улс төрийн шинжлэх ухааны тэр дундаа нам судлал, нам судлаачдын судалгааны тодорхой нэг хэсэг болон судлагдаж ирсэн авч хавсарга судалгааны шинжтэйгээр хөгжиж иржээ. “Намын бүтэц, зохион байгуулалтын задлан шинжилгээ нь нам судлалын ухааны уламжлалт хэсэг боловч судлагдаж танигдсаныхаа хувьд төдийлөн сэтгэлд хүрдэггүй юм”² хэмээн судлаач Анжело Панебианко дүгнэжээ. Намын үүсэл, бүтэц зохион байгуулалт нь эрх зүйн зохицуулалтын талаасаа гадаад болон дотоод гэсэн үндсэн хоёр хэм хэмжээний зохицуулалтаар зохицуулагддаг. Учир нь улс төрийн нам нь дотооддоо бүтэц, зохион байгуулалтын аппараттай, эрх зүйн хүрээнд өөрийн дэг жаягтай, тусгаар бие даасан бүтэц бүхий байгууллага. Энэ бүтэц өөрөө эрх зүйн бодит, тодорхой зохицуулалтыг шаардаж байдаг ба энэ нь доорх хоёр үндсэн шалтгаантай холбоотой.

1. Улс төрийн намууд төрийн засаглалыг хэрэгжүүлэх явцад олон нийтийн ашиг сонирхолыг идэвхтэйгээр төрийн бодлогод явдал нь тэдний легитимт шинжийн эх үндэс болдог. Ийм ч учраас намын бүтэц, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалт өдгөө улам бүр нарийссаар байгаа бөгөөд энэхүү байдлыг Германы хуульч В.Хенке тэмдэглэхдээ: “намуудын дотоод дэг жаягийг эрх зүйн механизмаар тогтоон бэхжүүлэх нь намуудын бүтцийн улам бүр нарийн зохион байгуулалттай болгоход ихээхэн ач холбогдолтой юм”³ хэмээжээ.

2. Улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын үндэс нь ардчилсан зарчмуудад тулгуурлаж тэр нь төрийн бүтцэд / төрийн механизмыг бүрдүүлэхэд / батжин бэхжих явдал нь хамгийн чухал юм. Тухайлбал: Намын дотоод бүтцийн энэ байдлыг Германы Үндсэн хуулинд “улс төрийн нам байгуулах эрх нь хүн бүрт нээлттэй бөгөөд гагцхүү байгуулагдсан намын үйл ажиллагаа нь төдийгүй бүтэц, зохион байгуулалт нь ардчилсан зарчимд үндэслэсэн байх ёстой” / 1-р бүлэг 21 зүйл / гэж заасан байдаг. Үүнийг улс төр судлаач К.Хессе тодотгон энэ заалт нь улс төрийн намуудыг үүсгэх, түүнчлэн улс төрийн үйл явцад эрх чөлөөг тогтоох, батлах, тэдний дотоод бүтцийг улам бүр ардчилсан болгоход чиглэгдэж байна хэмээн тэмдэглэсэн байна.

Авторитари, тоталитари улс төрийн дэглэм бүхий улс орнуудад намын дотоод ардчилал хэлбэр төдий байх агаад эрх зүйн зохицуулалт нь намын удирдах аппаратад үйлчлэхээр хуульчлагдсан байдаг аж. Энэхүү байдлыг судлаач В.Лапаева тэмдэглэхдээ “намын бүтцийн эрх зүйн зохицуулалтын ийм загвар нь эцсийн дүндээ тэржсэн намын аппаратыг бий болгодог. Энэ нь намын хувьд төдийгүй төрийн засаглалын орчинд бүр цаашлаад нийгмийн хүрээнд дарангуйллын тогтолцоог бий бүрэлдүүлдэг юм” хэмээжээ.

Тэгвэл улс төрийн намын бүтэц, бүрджилтийн эрх зүйн зохицуулалт ямар байвал хамгийн үр ашигтай байж, ардчилсан зарчимд нийцэх вэ? гэдэг асуудал нь өдгөө нам судлаачдын төдийгүй улс төрчдийн хамгийн их анхаарлаа

¹ В.И.Ленин зохиолууд. 17-р боть. 289-р тал

² Angelo Panebianco. Political parties; organization and power. Cambridge., 1998.3p.

³ Ю.Юдин. Политические партии и право в современном государстве. М., 1998 стр.214.

хандуулж буй асуудал болоод байна. Энэ талын эрх зүйн зохицуулалт ч дэлхийн улс орнуудад янз бүр байдаг аж. "Энэ нь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын үндэс нь олон хэлбэрийн цогц хуулиудаар зохицуулагдаж байдагтай холбоотой. Үүнд "үндсэн хууль, түүний хүрээний гол хуулиуд / сонгуулийн хууль, намуудын тухай хууль, парламент дахь улс төрийн намын бүлгийн тухай хууль / , тусгай хуулиуд / намын өдөр дутмын үйл ажиллагааг зохицуулж байдаг /, мөн дээд шүүхийн тогтоол, шийдвэр зэрэг олон хууль тогтоомжууд хамаарна". Энд зүйн зохицуулалтын зарим хэм хэмжээг харьцуулан жишиж үзэж болох юм.

Нэг: Улс төрийн намуудын тухай үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт нь дайны сүүлийн жилүүдэд бодит биелэлээ олжээ. Дайны дараа 1947 онд Итали, 1948 онд Япон, 1949 онд ХБНГУ, 1958 онд Франц Үндсэн хуулиндаа намын тухай тодорхой заалт оруулсан байна. Өдгөө улс төрийн намын зохион байгуулалтын асуудал үндсэн хуулийн зохицуулалтаас тойрч гарах аргагүй эрх зүйн объект болсон гэдэгтэй хэн ч маргахгүй. Энэ нь доорх үндэслэлүүдээр баталгаажиг байгаа юм. Үүнд:

1. Улс төрийн намын нийгэм-улс төрийн амьдралд гүйцэтгэх үүрэг роль нь улам бүр өсөн нэмэгдэж, тэлэх хандлагтай байна. Ийм ч учраас намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчмыг үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулах шаардлага бий болсон юм. Германы ҮХ-ийн 1-р бүлгийн 21-р зүйлд "Нам бол ард түмний эрх чөлөөний бодит илрэл мөн" хэмээн заасан байдаг бол Португалийн ҮХ-ийн 47-р зүйлд "нам нь ард түмний хүсэл зоригийн хэлбэршилтийг хангадаг улс төрийн засаглалын байгууллага" гэж заажээ. Испанийн ҮХ-ийн 6-р зүйлд нам нь улс төрийн үйл ажиллагааны үндсэн элемент" гэж тогтоосон байдаг бол Грекийн ҮХ-ийн 29-р зүйлд "Улс төрийн нам бол нийгэмд чөлөөт, ардчилсан улс төрийн дэглэмийг тогтоогч байх ёстой"² гэжээ. Гэтэл зарим улс оронд Үндсэн хуулиндаа намын тухай тусгай хавсралт тогтоол оруулсан байдаг. Тухайлбал: Грек 1975, Бразили 1969, Португали 1976, Испани 1978 онд тус тус ийм тогтоолыг баталсан байна.

Энэ талаар Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 10-р зүйлд "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно гэж заажээ. Дээрх улсуудын ҮХ-ийн заалтуудаас харахад намын үүсэл нь ард түмний сайн дурын нэгдэл дээр бий болж, бүтэц, зохион байгуулалт нь ардчилсан байх зарчмаар хийгдэхийг хуульчилжээ.

2. Улс төрийн намыг үүсгэн байгуулах үйл ажиллагаа үндсэн хуулиар баталгаажиг байгаа явдал нь хүний эвлэлдэн нэгдэх эрхийг хангаж байгаа ардчилалын нэг чухал шалгуур юм. / ХБНГУ-ын ҮХ-ын 21-р зүйл, Португалийн ҮХ-ийн 47-р зүйл, Испанийн ҮХ-ийн 6-р зүйл, г.м. /

Хоёр: Улс төрийн намуудын зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулж байдаг үндсэн гол хуулиудад улс төрийн намуудын тухай хууль, сонгуулийн тухай хууль, парламент дахь бүлгийн тухай хууль зэрэг салбар хуулиуд ордог. Эдгээр хуулиуд нь үндсэн хуулинд нийцсэн байхаас гадна улс төрийн намын зохион байгуулалтын үндэс, үйл ажиллагааны зарчим, нийгэм дэхь бусад институтүүдтэй харилцах харилцааны эрх зүйн орчинг бүрдүүлж өгдөгөөрөө амин чухал ач холбогдолтой. Монгол улсын Улс төрийн

¹ М.В.Баглая. Конституционное право зарубежных стран. М., 1999. стр. 175

² М.В.Баглая. Конституционное право зарубежных стран. М., 1999. стр. 175

намын тухай хуулийн 1-р бүлгийн 3-р зүйлийн 1-д “Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль болон тухайн намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй. гэж заасан бол ХБНГУ-ын улс төрийн намын тухай хуулийн 1-р бүлгийн 2-р зүйлд “Холбооны болон Муж улсын хэмжээнд олон түмний улс төрийн хүсэл зориг бүрэлдэн тогтох үйл явцад байнга, урт хугацааны турш нөлөөлж холбооны болон муж улсын парламентад олон түмнийг нөлөөлөн оролцохыг эрмэлздэг иргэдийн холбоог зохион байгуулалтын цар хүрээ, үйл ажиллагааны тогтвортой байдал, гишүүдийн тоо болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаараа дээрх зорилгыг хэрэгжүүлэх чин эрмэлзлэлээ олон нийтэд хангалттай батлан харуулж чадсан бол түүнийг улс төрийн нам хэмээн нэрлэнэ. Намын гишүүд нь зөвхөн хувь хүмүүс байна. Хэрэв аль нэг **нам зургаан жил дараалан холбооны болон муж улсын парламентын сонгуульд өөрийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөр оролцоогүй бол** улс төрийн намын эрх зүйн статусаа алдана” гэж заасан нь нам хэмээх байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн шалгуур тавьсан нь харагдана. Харин намын дотоод байгууллагын талаар АНУ-ын мужуудын сонгуулийн хуулиар 36 мужид намын ямар ч гишүүн удирдах дээд байгууллагад сонгогдох эрхтэй, 32 мужид хэнийг ч энэ байгууллагад сонгож болно, 28 мужид намын ээлжит хурлаар намыг удирдах байгууллагуудад ажиллах хүмүүсийг сонгоно хэмээн өөр хоорондоо ялгаатайгаар заасан байх аж.

Шинэчлэгдэн найруулагдаж гарсан Намын тухай Монгол улсын хуулийн 3-р бүлгийн 13-р зүйлд намын бүтэц, зохион байгуулалт, нам доторх байгууллагуудын шатлалыг дараах байдлаар хуульчилж өгчээ.” Намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна. Намын Их Хурлын чөлөөт цагт намын бага, бүгд хурал, тэдгээртэй адилтгах намын төлөөллийн төв байгууллагыг намын Их Хурлаар сонгож байгуулна. Сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Намын төлөөллийн төв байгууллага өдөр тутмын ажлыг эрхлэх намын гүйцэтгэх байгууллагыг байгуулан ажиллуулна. Нам энэ хуульд нийцүүлэн өөрийн онцлогт тохирсон зохион байгуулалтын бүтцийг төв, орон нутгийн түвшинд байгуулан ажиллуулна” хэмээн зохион байгуулалтын үндсэн механизмыг хуульчлан баталгаажуулжээ.

Гурав: Намын өдөр дутмын үйл ажиллагаа, зохион байгуулалтын үндсийг тодорхойлж, зохицуулж байдаг хуулиуд. Үүнд ихэнхдээ намаас өөрөөс нь боловсруулан гаргадаг корпоратив хэм хэмжээнүүд хамаарна. Энэ хэм хэмжээнүүд Үндсэн хууль болон бусад хуулиудад нийцсэн байх учиртай. Намын дотоод харилцааг зохицуулахад чиглэгдэн гарч байгаа хэм хэмжээний актууд нь тухайн улс орны онцлог, намуудын зохион байгуулагдах зарчим ялгаатайгаас үүдэн өөр өөр байгааг бид доорх баримтуудаас харж болох юм. Тухайлбал: Ангол, Бразиль, Коба-Верде, Уругвай зэрэг орнуудын улс төрийн намуудын дүрмүүдэд нийтлэг ажиглагдаж буй нэг зүйл бол намын удирдах дээд байгууллагад намын гишүүн бөгөөд намд **хариуцлагтай алба хашиж байгаа хүмүүсийг** намын ээлжит хурлаар сонгоно хэмээн заасан хэм хэмжээний зохицуулалт нь манай улс төрийн намуудын удирдах байгууллагаа байгуулахад мөрддөг дүрмийн заалтуудтай төсөөтэй байна. Гэвч намын дүрэм, журмын зохицуулалтын үндсэн зарчим нь намын тухай хуулийн заалтуудаас ангид байх аргагүй. Улс төрийн намын тухай Монгол улсын хуулийн 3-р бүлгийн 11.1-д Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна гээд үүнд намын Их болон бусад хуралд төлөөлөгч сонгох, оролцох, удирдах болон хяналтын байгууллага байгуулах, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай хамруулан ойлгоно гэжээ. Намын зохион байгуулалтын талаарх дээрх хуулийн заалт нь намын дүрэм болон бусад дотоод харилцааг зохицуулж байдаг хэм хэмжээний актуудын үндсэн мөрдлөг намуудын өдөр дутмын үйл ажиллагаанд хэрэгжиж байна.

Орчин үед олонх улс орнууд хууль батлан гаргахдаа улс төрийн намын үйл ажиллагаа, зохион байгуулалтын ерөнхий зарчмуудыг тогтоон батжуулж өгсөн байдаг. Юуны өмнө намын байгууллагуудын бүтцийн зарчим үүнд хамаарна. Ихэнх улсуудад нутаг дэвсгэрын байгуулалтын зарчим түгээмэл боловч намын байгууллагуудын бүтцийг тусгайлсан хуулиудаараа зохицуулсан байдал нь харилцан адилгүй. Юуны өмнө засаг захиргааны нэгжүүд дэхь намын байгууллагууд, тэдний бүтцэд ихээхэн анхаардаг байна.(тухайлбал: бразил болон мексикийн хуулиудад үндэсний, муж улсын, нутгийн захиргааны, хүрээлэн байгаа орчны байгууллага хэмээн зааж өгсөн байдаг байна.)Ийм тохиолдолд орон нутаг дахь намын байгууллагуудад тавих үндсэн шаардлагууд улам тодорхой болдог. ХБНГУ-ын намын хуулинд “ нутаг дэвсгэрийн нэгжүүд нь гишүүд, дэмжигчдийн тусгаар бие даасан байдлыг хангах, баталгаажуулах, намын үйл хэрэгт татан оролцох нөхцлийг бүрдүүлж ажиллахаар зохион байгуулагдсан байх ёстой”¹ гэж заажээ. Постсоциалист орнуудад улс төрийн нам нутаг дэвсгэрийн нэгжээр байгуулагдах зарчмыг алдагдуулсан хууль дүрмүүдийг батлан мөрдүүлж байсан нь харагддаг. ОХУ-д 1991онд гарсан Ерөнхийлөгчийн “улс төрийн намын болон нийгмийн олон нийтийн байгууллагын бүтэц, байгууллагуудын үйл ажиллагааг төрийн бие даасан байгууллагуудын үйл ажиллагаанд оролцохыг зогсоох тухай” зарлиг гарсан. 1996 онд ОХУ-ын Думаар хэлэлцэгдэж батлагдсан улс төрийн намын тухай хуулинд намын зохион байгуулалтын үйл ажиллагааг төрийн мэргэшсэн алба, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, зэвсэгт хүчин, хууль сахиулах байгууллага, хууль тогтоох байгууллагын ажлын аппаратын үйл ажиллагаанд оролцохгүй байх хориог улам бүр тодруулан өгчээ. Ер нь улс орнуудын хууль тогтоомжуудаас харахад улс төрийн намын үйл ажиллагаа, байгууллагын бүтцийн үндсэн зарчмууд ерөнхийдөө адилхан юм. Тухайлбал намууд удирдах дээд байгууллагатай байх. /их хурал, бага хурал, хурал/ Эдгээр байгууллагуудыг өөр нэрээр нэрлэх, өөрөөр байгуулах явдал байх авч нийтлэг чухал зарчим нь намын удирдах байгууллага сонгуулийн үр дүнд байгуулагдаж байхыг хууль, дүрмээр баталгаажуулж өгсөн байдагт оршино. Энэ бүгдийн эцэст намын дотоод байгууллагын эрх зүйн зохицуулалтын задлан шинжилгээ нь хоёр үндсэн дүгнэлтэнд хүргэж байна.

1.Эрх зүйн зохицуулалтын гол зорилго нь намын байгууллагуудын ардчилсан байх зарчмын үндсүүдэд нэвтэрсэн байдаг. Ийм шинжийг бид намын гишүүнчлэл чөлөөтэй, сайн дурын байх зарчим, намын үйл ажиллагаа, зохион байгуулалт нь нутаг дэвсгэрээр байгуулагдсан байх зарчим, намын удирдах дээд байгууллага, албан тушаалтныг сонгодог зарчим, нам доторх чухал тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахын тулд үе үе ээлжит бус хурал хийдэг байх зэрэг эрх зүйн зохицуулалт шаардсан үйл ажиллагаануудаас харж болно.

2.Намын дотоод байгууллагуудын хоорондын харилцааны эрх зүйн зохицуулалтын ерөнхий зарчим нь хэлбэржсэн тогтвортой байх ёстой.Намын дүрэм журам төдийлөн их өөрчлөгдөөд байдаггүй. Үүнийг Герман, АНУ-ын хууль эрх зүйг актууд тодорхой харуулж байгаа билээ.

Дээрхээс дүгнэж үзэхэд намын бүтэц зохион байгуулалт нь ямарваа байгууллагын нэгэн адил институтжих үйл явцаар бий болох ерөнхий зүй тогтолт үзэгдэл мөн боловч энэхүү үйл явц нь хууль эрх зүйн нарийн зохицуулалтын механизмыг шаардаж байдаг. Парламентат ёсны хөгжил бага / парламентын засаглалын хэлбэрийг сонгож аваад удаагүй, түүхэндээ парламентат ёсны уламжлалгүй /, түүнийгээ дагаад нам, намын системийн төлөөшилт сул байгаа Монгол орны хувьд дээрх асуудлыг нэлээд өргөн утга агуулгаар, зөвхөн нийгэмд улс төрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага гэдэг талаас нь биш, төрийг бүрдүүлэх, төрийн бодлого шийдвэрийг

¹ Ю.Юдин. Политические партии и право в современном государстве .1998., стр.138

гаргалцахад намын боловсон хүчний чадавхыг бүрэн дүүрэн ашиглах, дайчлах гэдэг утгаар нь цогц байдлаар хандах шаардлагтай. Учир нь намын бүтэц, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтын асуудалд Өрнөдийн хөгжингүй орнуудад зөвхөн нам доторх зохион байгуулалтын бүтцээс гадна төрийн институтуудыг бүрдүүлэх, тодруулбал хууль тогтоох байгууллагын бүтцэд байгаа намын гишүүд, бүлгүүдийг намын дотоод бүтцэд хамруулан хуульчилж харилцаа уялдаа холбоог нарийн гаргаж өгсөн байдаг байна. Энэ нь намын бодлого болон төрийн бодлогын уялдааг хангах, төр тогтвортой ажиллах, намаас төрийн удирдах албан тушаалд чадварлаг боловсон хүчнээ дэвшүүлэн ажиллуулах, хууль болон төрийн бодлого шийдвэр оновчтой гарахад иргэдийн санаа бодол, нийгмийн эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн тусгах толь болж өгдөг байна. Тиймээс ч өдгөө намын бүтэц зохион байгуулалт нь төвлөрсөн, хэт үзэл сурталжсан байдлаасаа ангижирч төрийн бодлого, шийдвэрийг ард иргэдэд хүргэхэд үйлчлэх тогтолцоо маягаар байгуулагдан ажиллах болжээ.

Ишлэл татсан ном, материалууд

1. Angelo Panebianco. Political parties: organization and power. Cambridge., 1998
2. Robert Michels. Political parties; A sociological study of the oligarchical tendencies of modern democracy. Illinois. USA., 1958
3. Gerald M. Pomper. Passion and Interests; Political party concepts of American democracy. University Press of Kansas., 1992
4. Ю.Юдин. Политические партии и право в современном государстве. М., 1998
5. М.В.Баглая. Конституционное право зарубежных стран. М., 1999
6. М.Дюверже. Политические партии. 2000
7. В.И.Ленин зохиолууд. 17-р боть. УБ. 1965 он.
8. УТБА-ийн лекцийн эмхтгэл. УБ., 2001
9. Монгол улсын Үндсэн хууль. УБ. 1992 он
10. Улс төрийн намын тухай Монгол улсын хууль. УБ. 2005 он
11. Монгол улсын Их Хурлын сонгуулийн хууль. УБ. 1992 он
12. Намын гишүүнээс татгалзвал зохих албан тушаалын тухай Монгол улсын хууль. УБ. 1991 он
13. ХБНГУ-ын улс төрийн намын тухай хууль. УБ., 2000 он